

МОНГОЛ УЛС  
ШҮҮХИЙН  
ИНДЕКС



2025



# МОНГОЛ УЛС ШҮҮХИЙН ИНДЕКС 2025



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



ОЮУНЫ  
ИННОВАЦИ  
ТББ

ОЮУНЫ  
ИННОВАЦИ

ННА 67  
ДАА 340  
М-692

**МОНГОЛ УЛС**  
**ШҮҮХИЙН ИНДЕКС 2025**

judindex.forum.mn

Санаачлагч  
**НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ**

Гүйцэтгэгч  
**ОЮУНЫ-ИННОВАЦИ ТББ**

Судалгааны баг  
Т.Алтангэрэл, “Оюуны-Инноваци” ТББ-ын УЗ-ийн дарга, хууль зүйн ухааны доктор  
Б.Төрболд, “Оюуны-Инноваци” ТББ-ын Гүйцэтгэх захирал  
П.Баттулга, “Оюуны-Инноваци” ТББ-ын Судлаач, хуульч  
Д.Аюуш, Социологич  
“Тунгаахуй өгөгдлийн урлан”-гийн дата аналисдын баг

Хянан тохиолдуулсан  
П.Бадамрагчаа, ННФ-ын Эрх зүйн хөтөлбөрийн менежер

Өгөгдлийн дүрслэл ба тайлангийн дизайн  
**ТУНГААХУЙ ӨГӨГДЛИЙН УРЛАН**

**НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ**

Жамьян гүний гудамж  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар - 14240  
976-76113207  
osf@forum.mn  
<http://www.forum.mn>

ISBN 978-9919-529-11-6  
© Нээлттэй Нийгэм Форум, 2026

# ГАРЧИГ

Өмнөх үг	4
Товчилсон үг	6
Хүснэгтийн жагсаалт	7

## ШҮҮХИЙН ИНДЕКС 2025 8

1.1 Танилцуулга	10
1.2 Шүүхийн индексийн хөтөч	18
1.3 Шүүхийн индекс 2025	20

## ШҮҮХИЙН ИНДЕКС ТООЦОХ АРГА ЗҮЙ 22

2.1 Зорилго	24
2.2 Шүүхийн индексийн шалгуур үзүүлэлт	24
2.3 Өгөгдлийн эх сурвалж	32
2.4 Шүүхийн индекс тооцох арга зүй	34

## ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ҮНДСЭН ХЭМЖИГДЭХҮҮН 42

3.1 Шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал	47
3.2 Шүүхийн нээлттэй, ил тод байдал	50
3.3 Шүүхэд итгэх олон нийтийн итгэл	52
3.4 Шүүхийн дэд бүтэц, нөөц	54
3.5 Шүүгчийн ёс зүй ба хариуцлага	56
3.6 Шүүхийн үр ашигтай үйл ажиллагаа	58

## ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ 60

4.1 Олон нийтийн санал асуулгын дүн шинжилгээ	64
4.2 Мэргэжилтнүүдийн санал асуулгын дүн шинжилгээ	68
4.3 Олон нийтийн санал асуулга ба мэргэжилтнүүдийн санал асуулгын харьцуулалт	71

## ХАВСРАЛТ 76

1. Шүүхийн индексийн үр дүнгийн нэгдсэн хүснэгт	76
2. Олон нийтийн санал асуулгын үнэлгээ	84
3. Мэргэжилтнүүдийн санал асуулгын үнэлгээ	86
4. Шүүгчийн ажлын ачааллын дэлгэрэнгүй өгөгдөл	89
5. Мэргэжилтнүүдийн санал асуулгын хуудас	95
6. Олон нийтийн санал асуулгын хуудас	101

## ӨМНӨХ ҮГ

Хууль дээдлэх ёс нь ардчиллын амин чухал зарчим, нээлттэй нийгмийн үнэт зүйл болохын учир **Нээлттэй Нийгэм Форум** сүүлийн 20 гаруй жилийн туршид шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх, хууль зүйн үйлчилгээний хүртээмж, иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх зорилго тавин ажиллаж ирлээ. 2008 оноос хойш шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэхэд иргэний нийгмийн хараат бус байр суурийг илэрхийлж, шүүхийн шинэтгэлийн чухал үе шатанд бодлогын судалгаа шинжилгээ, олон талын дуу хоолойг хүргэж байв.

2021 оноос эхлэн хэрэгжүүлсэн Монгол Улсын Шүүхийн индекс судалгааны төслийн гуравдах удаагийн тайлан бэлэн болж, энэхүү дэлгэрэнгүй тайланг уншигч Та бүхний анхааралд хүргэж байгаадаа баяртай байна. Шүүхийн үйл ажиллагааг хоёр жил тутамд үнэлдэг энэхүү судалгаа шүүхийн тухай хууль тогтоомж шинэчлэгдэж, шүүх эрх мэдлийн байгууллагууд шинэ эрх зүйн орчинд шинэ бүрэлдэхүүнээр ажиллах болсон үеэс эхтэй билээ. Цаг хугацааны тухайд Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэн эрхийн хугацаатай давхцан хийгддэг энэхүү судалгаа нь шинээр томилогдсон зөвлөлийн хувьд суурь болон явцын, улмаар бүрэн эрхийн хугацаа дуусах үеийн эцсийн үнэлгээ болдгоороо онцлог. Харин 6 жилийн хугацаатай томилогддог Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүний хувьд үйл ажиллагааны явцын 2 удаагийн үнэлгээ хийгдэх боломжтой юм.

Шүүхийн хүртээмж, үйл ажиллагааны шуурхай, үр нөлөөтэй, ил тод, шударга байдлыг бэхжүүлэхэд бодлогын болон төсвийн дэмжлэг ихээхэн нөлөөтэй болохыг энэ удаагийн индексийн дүн илтгэж байна.

Нийт 6 үзүүлэлт, 100 оноогоор хэмжигддэг энэхүү индексийн эхний дүн 2021 оны байдлаар үнэлэгдэн 2022 онд танилцуулагдсан бөгөөд 51.94 оноотой буюу дундаж үр дүнтэй гарч байв. Харин 2023 оны байдлаар үнэлэгдсэн хоёр дах удаагийн индекс 53.22 болж ялимгүй ахиц гарсан нь Шүүхийн сахилгын хороо байгуулагдаж, үйл ажиллагаа нь эхэлсэнтэй холбоотой байв. Энэ удаа танилцуулж буй гурав дах удаагийн индекс даруй 4.11 оноогоор өссөн үнэлгээтэй байгаа нь анхаарал татахуйц үр дүн юм.

Энэхүү ахиц дэвшил нь нийт шүүх эрх мэдлийн салбарын мэргэжилтэн, бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч албан тушаалтан, олон улсын хандивлагч байгууллагуудын хүчин зүтгэлийн үр дүн болохыг тэмдэглэхэд таатай байна. Цаашид энэхүү нааштай үр дүн улам бэхжиж, шүүхийн үйлчилгээний үр нөлөөг тууштай дээшлүүлнэ гэдэгт найдаж байна.

Шүүхийн салбарын бодлогын судалгаа, нөлөөллийн ажилд бидэнтэй хамтран ажиллаж ирсэн хараат бус эрх зүйн судалгааны байгууллага болох **“Оюуны-Инноваци” ТББ**-ын гүйцэтгэх захирал Б.Төрболд, ТУЗ-ийн дарга Т.Алтангэрэл, судлаач П.Баттулга, социологич Д.Аюуш, дата аналит Э.Тунгалаг, судлаач С.Цэрэндолгор нарт шүүхийн шинэтгэлийг гүнзгийрүүлэхэд чухал ач холбогдолтой энэхүү судалгааг өндөр хариуцлагатай хийж гүйцэтгэсэнд гүн талархал илэрхийлж, цаашдынх нь судалгаа шинжилгээний ажил үйлсэд амжилт хүсье.

Тэрчлэн, Шүүхийн талаарх олон нийтийн санал бодлын судалгааг энэ удаад дахин эрхлэн явуулсан судалгааны тэргүүлэх байгууллагуудын нэг болох **“ММСГ” компани**, индексийн өгөгдлийн дүрслэл, тайлангийн эх бэлтгэлийг хариуцан ажилласан **“Тунгаахуй өгөгдлийн урлан”**-гийн бидний хамтын бүтээлд оруулсан үнэтэй хувь нэмрийг тэмдэглэж, талархал илэрхийлье.

Тайланг цахим хэлбэрээр [www.judindex.forum.mn](http://www.judindex.forum.mn) хаягаар орж танилцах боломжтой. Шүүхийн индексийн арга зүй, тайланг цаашид боловсронгуй болгох аливаа ажил хэрэгч шүүмж, саналыг хүлээн авч хамтран ажиллахдаа ямагт таатай байх болно.

**П. ЭРДЭНЭЖАРГАЛ**

Гүйцэтгэх захирал

Нээлттэй Нийгэм Форум

## ТОВЧИЛСОН ҮГ

ЕХ	Европын холбоо
ЗМ	Захиргааны мэдээлэл
МСА	Мэргэжилтнүүдийн санал асуулга
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
ОНСА	Олон нийтийн санал асуулга
ТББ	Төрийн бус байгууллага
УБ	Улаанбаатар
УДШ	Улсын дээд шүүх
УЗ	Удирдах зөвлөл
УИХ	Улсын Их Хурал
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШСХ	Шүүхийн сахилгын хороо

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Шүүхийн жилийн тайлан, 2025 он	10
Хүснэгт 2.	Дундаж үнэлгээний өөрчлөлт, эх сурвалжаар, 2023-2025	15
Хүснэгт 3.	Шүүхийн индексийн үндсэн хэмжигдэхүүн, дэд хэмжигдэхүүн, шалгуур үзүүлэлтийн тоо	24
Хүснэгт 4.	Судалгааны түүврийн хэмжээ, бүсээр	32
Хүснэгт 5.	“2.8.1 Шүүхийн төсвийн зарцуулалтын тайланг тогтмол гаргаж, олон нийтэд мэдээлдэг.” шалгуур үзүүлэлтийн үнэлгээ	35
Хүснэгт 6.	“5.6.1.Шүүгчийн эсрэг гаргасан гомдол, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг нийтэд бүрэн, ил тод мэдээлдэг.” шалгуур үзүүлэлтийн үнэлгээний хэмжүүр	35
Хүснэгт 7.	“5.6.1 Шүүгчийн эсрэг гаргасан гомдол, түүний төрөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг нийтэд бүрэн, ил тод мэдээлдэг.” шалгуур үзүүлэлтийн үнэлгээ	36
Хүснэгт 8.	“6.1 Шийдвэрлэгдээгүй хэргийн тоо” дэд хэмжигдэхүүний үнэлгээ	37
Хүснэгт 9.	“6.2 Хэрэг шийдвэрлэлтийн хувь” дэд хэмжигдэхүүний үнэлгээ	38
Хүснэгт 10.	“6.3 Шүүгчийн ажлын ачаалал” дэд хэмжигдэхүүний үнэлгээ	39
Хүснэгт 11.	“6.4 Шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал” дэд хэмжигдэхүүний үнэлгээ	40
Хүснэгт 12.	“6.7 Шүүхийн шийдвэрийн биелэлт” дэд хэмжигдэхүүний үнэлгээ	41

---

1.1 ТАНИЛЦУУЛГА

1.2 ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ХӨТӨЧ

1.3 ШҮҮХИЙН ИНДЕКС 2025

---

# 1

● ШҮҮХИЙН  
ИНДЕКС 2025

# 1.1 ТАНИЛЦУУЛГА

## МОНГОЛ УЛСЫН ШҮҮХ

Шүүх эрх мэдлийн хүрээнд сүүлийн 2 жилд буюу 2024-2025 онд өрнөсөн үйл явдал, баталж хэрэгжүүлсэн бодлого, хууль эрх зүйн баримт бичиг зэргийг тоймлон зурагласнаар “Шүүхийн индекс 2025”-ын оноо, үр дүнг задлан шинжлэхэд уншигч Танд дөхөм болно гэж найдаж байна.

Шүүхийн статистикаас харахад Монгол Улсын шүүхэд 2024 онд 524, 2025 онд 517 шүүгч ажилласан бол энэ хугацаанд 1600 орчим шүүхийн захиргааны ажилтантай үйл ажиллагаа явуулжээ. Шүүхийн ачааллын статистикийг харвал дараах дүр зураг харагдана.

### Хүснэгт 1. Шүүхийн жилийн тайлан, 2025 он

Хэрэг маргааны төрөл		2024 он	2025 он	Зөрүү
1	Эрүүгийн хэрэг	14,682	15,712	+1,030
2	Иргэний хэрэг	73,727	95,408	+21,681
3	Захиргааны хэрэг	2,436	2,132	-304
4	Зөрчлийн хэрэг	45,183	54,738	+9,555
Нийт		136,028	167,990	+31,962

Шүүхийн ачаалал нь нийгэм эдийн засгийн болон эрүү, зөрчлийн хууль тогтоомжийн өөрчлөлт, эрх зүйн зохицуулалт хомс нийгмийн шинэ харилцаа зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан жил бүр нэмэгдэж байна.

Улмаар 5 жилийн өмнө буюу 2020 онд нийт 89,635 хэрэг, маргаан шийдвэрлэж байсантай харьцуулахад даруй 2 дахин ачаалал нэмэгдээд байна.

Эрх зүйн орчны хувьд “Шүүх байгуулах тухай хууль”<sup>1</sup>-ийн шинэчилсэн найруулга 2024 оны 6 сарын 5-ны өдөр батлагдсанаар нийт 90 шүүх ажиллаж байгааг 61 болгосон нь тогтолцооны хувьд том өөрчлөлт болов. Энэ хуулийн төсөлд давж заалдах шатны шүүхийг тойргийн журмаар байгуулах саналыг Улсын Дээд шүүх (УДШ), Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ) зөвшилцөн хуулийн төсөлд тусгуулсан хэдий ч Улсын их хурал (УИХ), Засгийн газрын түвшинд энэхүү саналыг дэмжээгүй болохыг дурдах нь зүйтэй. Хэрэв хуулийн төсөл энэ хувилбараар батлагдсан бол 21 аймаг дахь давж заалдах шатны шүүх 4 том бүсийн зохион байгуулалттай болох байв.

Шинэчлэн баталсан Шүүх байгуулах тухай хуулиар дүүргийн шүүхийг эрүү, иргэний хэргээр дагнасан, тэгэхдээ тойргийн журмаар, сум дундын шүүхийг эрүү, иргэний хэргээр дагнуулахгүйгээр нэг шүүхтэй байхаар заасан. Харин эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хэргийн болон нутаг дэвсгэрийн харьяаллын талаарх хуучин зохицуулалт хэвээр хадгалсан байна.

<sup>1</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140721145671>

Энэ хуулийн нэг онцлог нь нийслэлийн төвийн 6 дүүрэг болох Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрийн харьяаллаар иргэний хэргийн хувьд үнийн дүн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор эд хөрөнгө, эрхийг битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах ажиллагаатай холбоотой гомдол, гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах нэхэмжлэл, ажилд эгүүлэн тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэн ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх олговор гаргуулах нэхэмжлэл зэргийг шийдвэрлэх, эрүүгийн хэргийн хувьд гэмт хэрэг үйлдсэн нь нотлох баримтаар нотлогдсон, гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа сайн дураараа хүлээн зөвшөөрсөн, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулж гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн, гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, хор уршгийг нөхөн төлсөн, эсхүл нөхөн төлөхөө илэрхийлсэн хэргийг прокурорын шатанд ял, эрүүгийн хариуцлагыг тохиролцож шүүхэд шилжүүлсэн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийг байгуулж, 2025 оны 01 дүгээр сарын 01-ээс ажиллуулж эхэлсэн явдал юм.

Хялбар ажиллагааны шүүх нь таслан сэргийлэх арга хэмжээний санал буюу тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, хязгаарлалт тогтоох, цагдан хорих, сэжигтнийг баривчлах, сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчлах мөрдөгч, прокурорын саналыг хүлээн авч шийдвэрлэж байна.

Түүнчлэн Шүүх байгуулах тухай хуулиар гэр бүл, хүүхдийн дагнасан шүүх байгуулахаар шийдвэрлэсэн нь шүүхийн тогтолцооны хувьд шинэ хуудас нээсэн бөгөөд 2026 оны 01 дүгээр сарын 01-ээс үйл ажиллагааг нь эхлүүлэхээр заасан хэдий ч бэлтгэл

ажил хангагдаагүйгээс 2026 оны 5 дугаар сарын байдлаар үйл ажиллагаа хараахан эхлээгүй байна.

Эдгээр дагнасан шүүхийн үйл ажиллагааг жигдлэхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгайлсан хууль, бэлтгэгдсэн шүүгч, шүүхийн захиргааны ажилтнууд, тусгай стандарт бүхий шүүхийн байр, үйлчилгээ зэрэг бэлтгэл, хөрөнгө оруулалт шаардлагатай.

2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн УИХ-ын 33-р тогтоолоор 2024-2034 онд хэрэгжих Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогыг<sup>2</sup> баталсан нь цаашид шүүхийн хөгжлийн бодлогын залгамж, тууштай байдлыг хангах суурь боллоо. Энэхүү бодлогын баримт бичиг нь дараах 7 зорилтыг тодорхойлж, хэрэгжүүлэх төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн боловсруулсан байна. Үүнд:

1. Шүүхэд мэдүүлэх иргэний эрхийн баталгааг хангаж, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг дээшлүүлнэ.
2. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хариуцлагатай шүүхийг төлөвшүүлнэ.
3. Шүүх эрх мэдлийн байгууллагын захиргааны менежментийг хөгжүүлнэ.
4. Шүүхийн хүний нөөцийн чадавхыг хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тасралтгүй хөгжүүлнэ.
5. Шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
6. Шүүхийн үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлнэ.
7. Хэрэг хянан шийдвэрлэхэд тохирсон, тогтвортой, урьдчилан тооцоолсон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлнэ.

<sup>2</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140731305041&showType=1>

Эдгээр зорилгуудаас харахад Шүүхийн индекс судалгааны үндсэн 6 хэмжигдэхүүнтэй агуулга нэгтэй байх бөгөөд энэхүү бодлогын баримт бичиг хэрэгжсэнээр Шүүхийн индексийн оноонд нааштай нөлөө үзүүлэхээр байна.

Шүүхийн төсвийн асуудал өнөө хэр нь шүүх эрх мэдлийн хөгжилд томоохон сорилт болсон хэвээр байна. Үндсэн хуулийн Дөрөвдүгээр бүлгийн Дөчин наймдугаар зүйлийн 3-д “Шүүх улсын төсвөөс санхүүжнэ. Шүүх үйл ажиллагааг явуулах эдийн засгийн баталгааг төр хангана” гэж, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн тавдугаар зүйлд Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгааг зохицуулахдаа 5.6-д “Шүүх бие даасан төсөвтэй байх бөгөөд шүүхээс үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах нөхцөлийг төр хангана. Шүүхийн төсвийн урсгал зардлын хэмжээг төсвийн хэмнэлтээс бусад тохиолдолд өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно” гэж тус тус заасан.

2024 онд шүүхийн төсөв нийт 171,153 сая төгрөг байсан бол 2025 онд 276,306 сая төгрөгөөр батлагдаж, 2014 оноос хойш анх удаа хөрөнгө оруулалтын төсөв батлагдаж, шүүхийн шинэ байр барих, цахим шилжилтийн үйл ажиллагааг эхлүүлэх зэрэг боломж бүрдсэний дээр шүүгч болон шүүхийн захиргааны ажилтнуудын цалинг 2013 оноос хойш анх удаа нэмэгдүүлсэн байна.

ШЕЗ нь шүүхийн бие даасан байдлыг хангах ажлын хүрээнд Шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.11-д заасанчлан шүүхийн Тамгын газрын үйл ажиллагаанд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого батлах, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байдаг. Тэгвэл 2024-2025 онд шүүхийн цахимжилтыг шинэ шатанд гаргахад чухал суурь болсон дараах бодлогын баримт бичгийг баталжээ. Үүнд:

- ШЕЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 01-ний

өдрийн “Шүүхийн цахим шийдлийн энтерпрайз архитектур, техник эдийн засгийн үндэслэлийг батлах тухай” 44 дүгээр тогтоол;<sup>3</sup>

- Монгол Улсын шүүхийн цахимжилтын хөгжлийг үндсэн хоёр шатанд хувааж үзэж болох бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн “Цахимжилтын нэршил тогтоох тухай” 230 дугаар тогтоолоор дараах нэршлийг өгөхөөр тогтсон. Үүнд:
  - Шүүхийн үйл ажиллагаанд 2024 он хүртэлх хугацаанд нэвтрүүлсэн системийн бүх бүрдлийг “Цахим шүүх 1.0” гэж;
  - 2025 оноос шинээр нэвтрүүлэх шүүхийн цахим шийдлийн энтерпрайз архитектурын зөөлөн дэд бүтцийн цахим системийн бүрдлийг “Цахим шүүх 2.0” гэж, цахим хаягийг “ecourt.mn” гэж нэршүүлэхээр тус тус тогтоожээ.

ШЕЗ 2022 онд “Шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээний удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх бодлого”-ыг баталж, 2023 онд цахим шүүхийн энтерпрайз архитектур, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, 2024 оноос “Цахим шүүх 2.0” цөм системийн хөгжүүлэлтийг албан ёсоор эхлүүлээд байна.

“Цахим шүүх 2.0” цөм системийн хүрээнд шүүх тогтолцооны өгөгдлийн цөм систем буюу суурь платформ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем, шүүхийн цахим архив, иргэн, хуулийн этгээд хэргийн оролцогчийн систем, өгөгдөл солилцох, дэмжих дэд бүтэц буюу интеграци, шүүхийн захиргааны үйл ажиллагааны /ERP/ систем гэсэн 7 үндсэн систем нэвтрүүлэх юм.

Улмаар 2025 оны 12 сарын 19-ний өдөр “Цахим шүүх 2.0” цөм систем нээлтээ хийжээ. Шинэ интерфэйс бүхий иргэд, олон нийтэд зориулсан цахим систем

<sup>3</sup> <https://www.itrii.mn/media/uploads/2025/06/15/ononchimeg-tsahimjilt.pdf>

ажиллаж эхэлснээр иргэд болон хуулийн этгээдүүд шүүхэд хандах цаг хугацаа, зардлаа хэмнэх, иргэд гар утаснаасаа шүүхийн үйлчилгээг авах, орон зай, цаг хугацаанд баригдахгүйгээр үйлчилгээ авах боломж нээгдэж, шүүхийн үйлчилгээ түргэн шуурхай, чирэгдэлгүй, хүртээмжтэй болж, чанар сайжирна гэсэн хүлээлттэй байна.

2025 оны сүүлийн хагаст ШЕЗ-ийн эхний бүрэлдэхүүний бүрэн эрхийн хугацаа дуусаж, шинэ бүрэлдэхүүн томилогдох цаг хугацаа давхацлаа. 2024 онд ШЕЗ-ийн шүүгч бус нэг гишүүн бүрэн эрхийн хугацаанаас өмнө ажлаа өгсөнтэй холбоотой ээлжит бус сонгон шалгаруулалт зарлаж шинэ гишүүн томилсноор нийт шүүгчийн чуулганаас сонгох шүүгч гишүүний тоо 5, нээлттэйгээр нэр дэвшүүлж УИХ-аас томилох шүүгч бус гишүүний тоо 4 болсон юм. УИХ-аас томилох шүүгч бус 4 гишүүний сул орон тоонд нийт 24 хүн өрсөлдсөнөөс УИХ 2 гишүүнийг томилж, 2026 оны 4 сарын байдлаар нийт 8 гишүүнтэй ажиллаж байна.

Шүүхийн бие даасан байдал, шударга ёс, шүүхийн үр ашиг, шударга ёсны хүртээмжийг олон улсын хэмжээнд хэмждэг хэд хэдэн индекс, үнэлгээнүүд байдаг. Гэвч эдгээрээс аль нь ч Монголын шүүхийн индексийн 6 хэмжигдэхүүнтэй агуулгын хувьд бүрэн дүйцэхгүй байна. Ихэнх олон улсын үнэлгээ нь илүү өргөн хүрээтэй “хууль дээдлэх ёс”-ыг бүхэлд нь хамрах, эсхүл зөвхөн шүүхийн хараат бус байдал, эсвэл шүүхийн үр ашиг, үйлчилгээний чанарыг зэргийг онцлон хэмждэг. Тухайлбал, Дэлхийн шударга ёсны төслийн Хууль дээдлэх ёсны индекс (WJP Rule of Law Index) нь Хууль дээдлэх ёс, шүүхийн хүртээмж, иргэний ба эрүүгийн шударга ёс, шүүхийн нөлөөллөөс ангид байдлыг түлхүү хэмждэг бөгөөд шүүхийн институтээс гадна хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг хэмждэг. 2024-2025 оны хувьд 0.53 оноотой<sup>4</sup> байгаа нь сүүлийн жилүүдийн хувьд харьцангуй тогтвортой байгаа гэж үзэж болно. Энэ индексээс шүүх болон хууль сахиулах институтын үйл ажиллагааны үнэлгээг

салгаж авч үзэхэд хүндрэлтэй хэдий ч олон улсын хувьд хууль дээдлэх ёсны хэрэгжилтийг бусад улстай харьцуулах боломж олгодоггоороо онцлогтой.

Шүүх эрх мэдлийн хүрээнд сүүлийн жилүүдэд гарч буй өөр нэг эерэг өөрчлөлт нь олон улсын байгууллагуудын техник тусламж, төсөл хөтөлбөрийн дэмжлэг нэмэгдсэн явдал юм. Тухайлбал, Европын холбоо (ЕХ)-ны Хосолмол түншлэлийн хөтөлбөрийн дэмжлэгтэй “Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь” төсөл бөгөөд 2025 оны 7 дугаар сард нээлтээ хийсэн тус төсөлд УДШ, Шүүхийн академи, ШЕЗ, Шүүхийн сахилгын хороо (ШСХ) хамрагдаж байна. УДШ болон Шүүхийн академи “Шүүх эрх мэдлийн байгууллагын чанарыг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх”, ШЕЗ “Шүүхийн тогтолцооны гүйцэтгэл, хариуцлагыг нэмэгдүүлэх”, ШСХ “Шүүхийн тогтолцооны хүртээмж, шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх” гэсэн хүрээнд төслийг хэрэгжүүлэх ажээ.

Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO) ШЕЗ-тэй хамтран ЕХ-ны санхүүжилттэй “Шүүх эрх мэдлийн байгууллагын хамтын ажиллагаа ба ил тод байдал” төслийг 2024 оноос эхлэн хэрэгжүүлсэн бөгөөд одоогийн байдлаар хүүхдэд шударга ёсны хүртээмжийг нэмэгдүүлэх болон арилжааны эвлэрүүлэн зуучлалын эрх зүйн орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлэх төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Түүнчлэн Канадын Холбооны шүүхийн хэрэг эрхлэх газрын дэмжлэгээр “Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд” төсөл 2025 онд нээлтээ хийсэн бөгөөд “Шүүхийн хараат бус байдал, институтын шударга байдал”, “Шүүхэд итгэх олон нийтийн итгэл” болон “Шударга ёсны хүртээмж ба шүүхийн байгууллагуудын хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх” гэсэн үндсэн чиглэлээр 2025-2030 онд хэрэгжих юм.

<sup>4</sup> <https://worldjusticeproject.org/rule-of-law-index/country/2025/Mongolia/>

## ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ТОЙМ

Монгол Улсын шүүхийн индекс нь тухайлан шүүхийн салбарт өрнөж буй шинэтгэлийн үр нөлөөг хараат бусаар үнэлж, аливаа ухралтаас сэргийлэх, хэрэгжилтийн шатанд эрчимжүүлэх шаардлагатай асуудлыг тодорхойлж байгаа бөгөөд олон улстай харьцуулах гэхээс илүү цаг хугацааны хувьд харьцуулж, хоёр жил тутамд хэмжих болно.

Шүүхийн тухай хууль батлагдсан 2021 онд анхны индексийн судалгааг хийсэн нь тус хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг индексээр дамжуулан үнэлэх давхар зорилгыг агуулсан билээ. 2023 онд хийгдсэн хоёрдох удаагийн индексийн судалгаа нь 2021 онд шинээр байгуулагдсан ШЕЗ, ШСХ-ны үйл ажиллагааны үр нөлөөг үнэлсэн бол 2025 оны энэ удаагийн индекс нь 2025 оны сүүлээр бүрэн эрх дууссан ШЕЗ-ийн эхний бүрэлдэхүүний 4 жилийн ажилд дүн тавихын зэрэгцээ шинээр томилогдсон бүрэлдэхүүний хувьд гарааны цэгийг тодорхойлж өгч байгаагаараа онцлогтой.

Шүүхийн индекс нь (1) шүүхийн үйл ажиллагааны төлөв байдлыг олон талаас бодитойгоор үнэлэх; (2) шалгуур үзүүлэлтийн хариунд үндэслэн шүүхийн тулгамдсан асуудал, хүндрэл, бэрхшээлийг оношлох; (3) төлөв байдал, тулгамдсан асуудлын үндсэн дээр шүүхийн хүрээнд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, чиг хандлагыг тодорхойлоход чухал хэрэгсэл юм. Өнгөрсөн 4 жилийн хугацаанд энэхүү индексийн судалгаа нь шүүх эрх мэдлийн хүрээнд болон шударга ёсны салбарт үйлчлэх бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн үндэслэл, үзэл баримтлалд дурдагдан, тэдгээрийн үр нөлөөг хэмжих эх сурвалжийн нэг гэж хүлээн зөвшөөрөгдөөд байна.

Судалгааны цар хүрээ нь “шүүх эрх мэдэл” гэж өргөнөөр бус “шүүх” гэж тодорхой институтийн хүрээнд авч үзсэн бөгөөд үүнд, бүх шатны шүүх, шүүхийн захиргааны болон шүүхийн хариуцлагын институтийг хамруулдаг билээ. Түүнчлэн олон улсад индексийг аль нэг хэмжигдэхүүнд тулгуурлаж, тухайлбал ил тод байдал, шударга, хараат бус байдал гэх зэргээр нэрлэдэг бол бид шүүхийн үйл ажиллагааг хэмжиж болохуйц бүх талын шалгуурыг оруулан шүүхийн талаарх үндэсний хэмжээний индекс хэмээн нэршлийг ерөнхий байдлаар томьёолон хэрэглэхээр шийдсэн юм.

Монгол Улсын шүүх 2025 оны байдлаар олон нийтийн санал бодол, салбарын шинжээч, мэргэжилтнүүдийн санал бодол, захиргааны мэдээлэл гэсэн үндсэн гурван эх сурвалжаас цугласан мэдээллийг тоон илэрхийлэлд хувирган үнэлсэн индексэд нийт боломжит 100 онооноос 57.33 оноог авсан нь 2021 оноос 5.39, 2023 оноос даруй 4.11 оноогоор ахисан үзүүлэлт юм. Энэхүү нэгдсэн оноо нь (1) Шүүхийн нээлттэй, ил тод байдал, (2) Шүүгчийн ёс зүй ба хариуцлага, (3) Шүүхэд итгэх олон нийтийн итгэл, (4) Шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал, (5) Шүүхийн үр ашигтай ажиллагаа, (6) Шүүхийн дэд бүтэц, нөөц гэсэн үндсэн зургаан хэмжигдэхүүн, түүнээс улбаалсан 42 дэд хэмжигдэхүүн, тэдгээрийг илэрхийлэх 111 шалгуур үзүүлэлтэд үндэслэн гарч байгаа бөгөөд эдгээрийг хэрхэн тайлж уншихыг тайлангийн хөтөч болон арга зүйн хэсгээс дэлгэрүүлэн харна уу.

Шүүхийн индексийн онооны өсөлт нь бүх хэмжигдэхүүнд бус харин 4 хэмжигдэхүүний өсөлтөөс шалтгаалсан байна. Тухайлбал, Шүүхэд итгэх олон нийтийн итгэл 7.33, Шүүхийн дэд бүтэц, нөөц 7.23, Шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал 5.86, Шүүгчийн ёс зүй хариуцлага 3.70 оноогоор өссөн нь нийт оноонд эергээр нөлөөлжээ. Үлдсэн хэмжигдэхүүний хувьд тоймтой өсөлт харагдахгүй ч онооны хувьд буураагүйг онцлох нь зүйтэй.

Шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал хэмжигдэхүүний хувьд 7 дэд хэмжигдэхүүн 3.09-7.71 оноогоор бүгд харьцангуй өндөр өсөлттэй гарсан байх бөгөөд шалгуур үзүүлэлтийн түвшинд авч үзвэл шүүхийн тогтолцоонд авлига нөлөөлдөггүй гэх асуултад хуульч мэргэжилтнүүдийн хариу 38.04-өөс 63.45 болж буюу даруй 25.41 онооны үсрэнгүй өсөлт гаргасан нь чухал түлхэц болжээ. Энэ асуултад өгсөн олон нийтийн хариулт ч мөн 4.37 оноогоор дээшилжээ. Энэ мэтчилэн хуульч мэргэжилтнүүдийн шүүхийг үнэлэх үнэлэмж энэ удаад нэлээн эерэг үнэлгээтэй байгаа нь шүүхийн индексийн оноонд жинтэй нөлөө үзүүлсэн байна.

2025 оны өсөлтийг илүү нарийн түвшинд авч үзвэл авлигын нөлөөлөл буурсан гэх ойлголт, бие даасан байдлын баталгааны үнэлгээ, гүйцэтгэх эрх мэдэлд тавих хяналт, шүүгчийн хараат бус байдал, ШЕЗ-ийн хараат бус байдал, төсөв, нөөцийн үнэлгээ хүчтэй ахисан байна. Эдгээр нь сүүлийн 2 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааны үр дүн гэж үзэж байна. Түүнчлэн улс төрчдийн зүгээс байнга үзүүлж ирсэн дайралт, сөрөг мэдээллийн эрчим суларсан нь олон нийтийн санаа бодолд нөлөөлсөн байж болно.

2025 оны хувьд Хөгжлийн банкны болон Нүүрсний гэх тодотголтой хэргүүд анхан болон давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэгдсэн бөгөөд авлига албан тушаалын хэрэг маргаан 200 гаран шийдвэрлэгдсэн зэрэг нь олон нийтийн санал бодолд мөн нөлөөлсөн нь дамжиггүй.

Шүүхийн индекс нь адил жин дарах үндсэн гурван эх сурвалжийн нийлбэрээр оноог гаргадаг. 2025 оны хувьд эх сурвалж бүрээр онооны өөрчлөлт ямар байгааг дараах хүснэгтэд харуулав.

## Хүснэгт 2. Дундаж үнэлгээний өөрчлөлт, эх сурвалжаар, 2023-2025

	Эх сурвалж	2023	2025	Зөрүү
1	Олон нийтийн санал асуулга (Түүврийн хэмжээ: 2009)	51.79	57.25	+5.46
2	Мэргэжилтнүүдийн санал асуулга (Түүврийн хэмжээ: 500)	52.71	57.93	+5.22
3	Захиргааны мэдээлэл	<b>60.37</b>	<b>58.08</b>	<b>-2.29</b>

Олон нийтийн болон хуульч мэргэжилтнүүдийн санаа бодлын үнэлгээ 5 оноогоор нэмэгдсэн бол захиргааны мэдээлэлд үндэслэдэг оноо нь буурсан байгаа нь шүүхийн бодит статистик мэдээллийн хүрээнд ачаалал болон хэрэг шийдвэрлэлтийн хувь зэрэг үзүүлэлтээр оноо буурсан нь нэгдсэн дүнд нөлөө үзүүлсэн байна.

Тухайлбал, дүүргийн иргэний хэргийн шүүхийн ачаалал болон шинээр байгуулагдсан Эрүү, иргэний хялбар ажиллагааны шүүхийн ачаалал маш их байгааг тоон мэдээнээс харж болно. Захиргааны мэдээллийг тооцсон томьёоллыг 2 дугаар бүлгээс дэлгэрэнгүй уншиж танилцана уу.

2025 оны шүүхийн индексийн өсөлт нь үндсэндээ шүүхэд итгэх итгэл, бие даасан байдал, дэд бүтэц, нөөцийн чадавх сайжирсантай шууд холбоотой байна. Харин нээлттэй байдал, үр ашиг зэрэг нь зарим эх сурвалжийн үнэлгээний хувьд сул гарсан хэдий ч энэ нь санаа чилээхүйц тийм ч сөрөг үр дүн биш юм.

Энэ удаагийн индекс нь 2021 онд анх шинээр бүрэлдсэн ШЕЗ, ШСХ-ны үйл ажиллагааг 4 жилийн хугацаанд үнэлэх хөндлөнгийн үнэлгээ болж байгаагийн зэрэгцээ 2025-2026 оны заагт шинээр томилогдсон ШЕЗ-ийн бүрэлдэхүүний хувьд гарааны үнэлгээ болж байгаагаараа онцлогтой гэдгийг дурдах нь зүйтэй.

## ХЯЗГААРЛАЛТ

- Шүүхийн индекс нь 2025 оны мэдээлэлд түлхүү үндэслэсэн хэдий ч асуумжийн хүрээнд 2024 оныг хамруулан асуусан тохиолдол бий.
- 2021 онд батлагдан 2021 оны сүүлээс бүрэн хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой өмнөх 2021 оны индексийн тайланд шинэ Шүүхийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байлаа. Харин 2025 оны индексийн оноонд Шүүхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөө зарим талаар туссан гэж үзэж болно.
- Бүх индексүүдийн нэгэн адил энэхүү индексийг аливаа хувь хүний үнэт зүйлс, үзэл бодлын учир шалтгааны хамаарлыг тайлбарлахад ашиглахгүй. Энэхүү индексийн үнэлгээг Монгол Улсын шүүхийн цорын ганц бөгөөд бие даасан үнэлгээ гэж үзэхгүй.
- Судалгааны баг индексийн оноог тооцоолох болон жинлэх, оноо өгөх арга зүйг боловсруулах үүрэг гүйцэтгэсэн ч санал асуулгад өгсөн хариултуудад ямар ч нөлөө үзүүлээгүй болно.

## 1.2 ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ХӨТӨЧ

### ШҮҮХИЙН ИНДЕКС ГЭЖ ЮУ ВЭ?

Шүүхийн индекс нь шүүхийн үйл ажиллагааг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу олон талаас нь бодитоор хэмжиж, үнэлэх хэрэгсэл юм.

### ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Шүүхийн индекс нь шүүхийн үйл ажиллагааг 6 үндсэн хэмжигдэхүүн, 42 дэд хэмжигдэхүүнд хуваагдсан 111 шалгуур үзүүлэлтээр хэмжсэн.

### ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

#### 1 ШҮҮХИЙН ЭРХ ХЭМЖЭЭ, БИЕ ДААСАН БАЙДАЛ

Дэд хэмжигдэхүүн 7  
Шалгуур үзүүлэлт 27

#### 2 ШҮҮХИЙН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ

Дэд хэмжигдэхүүн 9  
Шалгуур үзүүлэлт 16

#### 3 ШҮҮХЭД ИТГЭХ ОЛОН НИЙТИЙН ИТГЭЛ

Дэд хэмжигдэхүүн 6  
Шалгуур үзүүлэлт 19

#### 4 ШҮҮХИЙН ДЭД БҮТЭЦ, НӨӨЦ

Дэд хэмжигдэхүүн 7  
Шалгуур үзүүлэлт 15

#### 5 ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ БА ХАРИУЦЛАГА


Дэд хэмжигдэхүүн 6  
Шалгуур үзүүлэлт 12

#### 6 ШҮҮХИЙН ҮР АШИГТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дэд хэмжигдэхүүн 7  
Шалгуур үзүүлэлт 22


## ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ОНОО

Шүүхийн индекс, түүний үндсэн хэмжигдэхүүн, дэд хэмжигдэхүүн, шалгуур үзүүлэлт бүрийг 0-100 оноогоор үнэлсэн. 0 оноо нь хамгийн сул, 100 оноо нь хамгийн сайн утгыг илэрхийлнэ.



## ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Шүүхийн индекс тооцсон шалгуур үзүүлэлтүүдийг (1) захиргааны мэдээлэл, (2) олон нийтийн төсөөллийн санал асуулга, (3) мэргэжилтнүүд (шүүгч, прокурор, өмгөөлөгч, бусад хуульч)-ийн санал асуулга гэсэн гурван төрлийн эх сурвалжаас бүрдүүлсэн.



## ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН НЭЭЛТТЭЙ ӨГӨГДӨЛ

Шүүхийн индексийн тайлан болон нээлттэй өгөгдлийг [www.judindex.forum.mn](http://www.judindex.forum.mn) холбоосоор орж авах боломжтой




# ШҮҮХИЙН ИНДЕКС

Үндсэн хэмжигдэхүүний оноо



# ШҮҮХИЙН ИНДЕКС

Ерөнхий оноо



◆ 100 оноо

◆ Шүүхийн индексийн тухайн оны оноо

---

2.1 ЗОРИЛГО

2.2 ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2.3 ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

2.4 ШҮҮХИЙН ИНДЕКС ТООЦОХ АРГА ЗҮЙ

---

# 2

- ШҮҮХИЙН  
ИНДЕКС  
ТООЦОХ  
АРГА ЗҮЙ

## 2.1 ЗОРИЛГО

Шүүхийн индекс нь шүүхийн шинэтгэлийн үйл явцад тогтмол, бодитой үнэлгээ өгөх, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох зорилготой.

Шүүхийн индекс нь (1) шүүхийн үйл ажиллагааны төлөв байдлыг олон талаас бодитойгоор үнэлэх; (2) шалгуур

үзүүлэлтийн оноонд үндэслэн шүүхийн тулгамдсан асуудал, хүндрэл, бэрхшээлийг тодорхойлох; (3) төлөв байдал, тулгамдсан асуудлын үндсэн дээр шүүхийн хүрээнд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, чиг хандлагыг тодорхойлох чухал хэрэгсэл юм.

## 2.2 ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Шүүхийн индекс нь үндсэн хэмжигдэхүүн, дэд хэмжигдэхүүн, шалгуур үзүүлэлт гэсэн гурван түвшний бүтэцтэй.

Шүүхийн индексийн хүрээнд 6 үндсэн хэмжигдэхүүн, 42 дэд хэмжигдэхүүнд хуваагдсан 111 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон. Үндсэн хэмжигдэхүүн, дэд

хэмжигдэхүүн, шалгуур үзүүлэлт тус бүрийг 0-ээс 100 оноогоор үнэлсэн бөгөөд 0 нь хамгийн сул, 100 нь хамгийн сайн гэсэн утгатай. Өөрөөр хэлбэл, индекс нь шүүх засаглалын өнөөгийн байдал хамгийн сулаас хамгийн сайн хувилбар хүртэлх зайд хэр хол байгааг хэмжинэ.

**Хүснэгт 3.** Шүүхийн индексийн үндсэн хэмжигдэхүүн, дэд хэмжигдэхүүн, шалгуур үзүүлэлтийн тоо

№	Үндсэн хэмжигдэхүүн	Дэд хэмжигдэхүүний тоо	Шалгуур үзүүлэлтийн тоо
1.	Шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал	7	27
2.	Шүүхийн нээлттэй, ил тод байдал	9	16
3.	Шүүхэд итгэх олон нийтийн итгэл	6	19
4.	Шүүхийн дэд бүтэц, нөөц	7	15
5.	Шүүгчийн ёс зүй ба хариуцлага	6	12
6.	Шүүхийн үр ашигтай үйл ажиллагаа	7	22
	<b>Нийт</b>	<b>42</b>	<b>111</b>

## ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ҮНДСЭН ХЭМЖИГДЭХҮҮН

Индексийн 6 үндсэн хэмжигдэхүүнийг шүүхийн үйл ажиллагааг харьцангуй тодорхой илэрхийлэх боломжтой гэж үзэн дараах байдлаар тодорхойлов: 1) Шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал; 2) шүүхийн нээлттэй, ил тод байдал; 3) шүүхэд итгэх олон нийтийн

итгэл; 4) шүүхийн дэд бүтэц, нөөц; 5) шүүгчийн ёс зүй ба хариуцлага; 6) шүүхийн үр ашигтай үйл ажиллагаа. Үндсэн хэмжигдэхүүн товч бөгөөд тодорхой байх нь дэд хэмжигдэхүүн, шалгуур үзүүлэлтийг нарийвчлахад дөхөмтэй юм.

### 1. ШҮҮХИЙН ЭРХ ХЭМЖЭЭ, БИЕ ДААСАН БАЙДАЛ

Шүүх бие даасан байх, шүүгч хараат бусаар, хөндлөнгийн аливаа зүй бус нөлөөллөөс ангид ажиллах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлын баталгаа.

### 2. ШҮҮХИЙН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ

Шүүхийн шийдвэр, үйл ажиллагаа олон нийтэд хүртээмжтэй байх, мэдээлэл авах боломж бүрдсэн байдал.

### 3. ШҮҮХЭД ИТГЭХ ОЛОН НИЙТИЙН ИТГЭЛ

Шүүх эрх мэдэл болон шүүгчийн мэдлэг, ур чадвар, ёс зүйд итгэх олон нийтийн итгэл, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны сэтгэл ханамжийн түвшин.

### 4. ШҮҮХИЙН ДЭД БҮТЭЦ, НӨӨЦ

Хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, хууль ёсны итгэлийг хамгаалахад буюу шүүхийн үйлчилгээг хэвийн, хүртээмжтэй явуулахад шаардлагатай хүний, санхүүгийн, материаллаг нөөцийн түвшин.

### 5. ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ БА ХАРИУЦЛАГА

Шүүгч хувийн ашиг сонирхлоос ангид байж, өндөр ёс зүйг чандлан сахих, шүүх бүрэн эрхээ хариуцлагатайгаар хэрэгжүүлэх, хариуцлага хүлээх чадвар.

### 6. ШҮҮХИЙН ҮР АШИГТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Шүүх хэргийг хугацаа алдалгүйгээр шийдвэрлэх чадвар, шүүхийн шийдвэрийн биелэлтийн түвшин.

# ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ҮНДСЭН БА ДЭД ХЭМЖИГДЭХҮҮН



# ИНДЕКС

## 4

ШҮҮХИЙН ДЭД  
БҮТЭЦ, НӨӨЦ

- 4.1 Шүүхийн үр ашгийн тухай төсөөлөл
- 4.2 Шүүхийн захиргааны үйлчилгээ
- 4.3 Шүүгчийн ажлын гүйцэтгэл
- 4.4 Шүүхийн харууцлагын тогтолцоо
- 4.5 Шүүхийн сахилгын зөрчлийн процесс
- 4.6 Шүүхийн сахилгын шийтгэл
- 4.7 Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

## 5

ШҮҮГЧИЙН ЁС  
ЭҮЙ БА  
ХАРИУЦДАГА

- 5.1 Шүүгчийн ёс зүй
- 5.2 Шүүгчийн сонгон шалгаруулалт
- 5.3 Шүүгчтэй холбоотой гомдлын мэдээлэл
- 5.4 Шүүгчийн мэдлэг, ур чадвар, дээшлүүлэх боломж
- 5.5 Шүүгчийн цалин хөлс
- 5.6 Шүүхийн захиргааны ажилтан

## 6

ШҮҮХИЙН ҮР  
АШИГТАЙ ҮЙЛ  
АЖИЛЛАГАА

- 6.1 Шийдвэрлэгдээгүй хэргийн тоо
- 6.2 Хэрэг шийдвэрлэлтийн хувь
- 6.3 Шүүгчийн ажлын ачаалал
- 6.4 Шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал
- 6.5 Шүүхийн үр ашгийн тухай төсөөлөл
- 6.6 Шүүхийн захиргааны үйлчилгээ
- 6.7 Шүүхийн шийдвэрийн биелэлт

- 5.1 Шүүгчийн ажлын гүйцэтгэл
- 5.2 Шүүгчийн харууцлагын тогтолцоо
- 5.3 Шүүгчийн сахилгын зөрчлийн процесс
- 5.4 Шүүгчийн сахилгын шийтгэл
- 5.5 Шүүгчийн ёс зүй
- 5.6 Шүүгчийн сонгон шалгаруулалт

## ДЭД ХЭМЖИГ ДЭХҮҮНИЙ ТАЙЛБАР

### 1. ШҮҮХИЙН ЭРХ ХЭМЖЭЭ, БИЕ ДААСАН БАЙДАЛ

Дэд хэмжигдэхүүн	Тайлбар
1.1. Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх	Хүн бүр шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах, хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх эрхтэй. Шүүх хүний хөрөнгө, орлого, нийгмийн гарал үүсэл, үндэс угсаа, байр суурь, улс төрийн үзэл баримтлал, нөлөөлөл, шашин шүтлэг, арьсны өнгө, бэлгийн чиг баримжаа, хүйсийн илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл зэргийг үл харгалзан алагчлалгүй, шударга ханддаг.
1.2. Хууль тогтоох эрх мэдэлд тавих шүүхийн хяналт	Үндсэн хуулийн цэц нь хууль, Улсын Их Хурлаас баталсан бусад шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэхийг тогтоох бүрэн эрхтэй бөгөөд бодит байдал дээр энэхүү эрх мэдлээ үр дүнтэй хэрэгжүүлдэг.
1.3. Гүйцэтгэх эрх мэдэлд тавих шүүхийн хяналт	Шүүх захиргааны байгууллагын захирамжилсан шийдвэр, үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавьдаг бөгөөд бодит байдал дээр энэхүү эрх мэдлээ үр нөлөөтэй хэрэгжүүлдэг.
1.4. Шүүхийн бие даасан байдал	Шүүхийн бие даасан байдлыг улс төрийн түвшинд хүлээн зөвшөөрдөг, шүүхийн төсөв хангалттай, хүрэлцээтэй, гүйцэтгэх эрх мэдэл шүүхийн шийдвэрийг хүндэтгэн биелүүлдэг.
1.5. Шүүгчийн хараат бус байдал	Шүүгч аливаа улс төрийн болон хувийн ашиг сонирхлоос ангид байж, эрх мэдлээ хэтрүүлэн ашигладаггүй, хуулийн дагуу хараат бусаар хэрэг, маргааныг хянан шийдвэрлэдэг. Шүүгчийн хараат бус байдлыг хуулиар баталгаажуулж, бодит байдал дээр хэрэгжүүлдэг.
1.6. Шүүхийн ерөнхий зөвлөл	Шүүхийн ерөнхий зөвлөл нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, улс төрч болон бусад аливаа этгээдээс хараат бусаар ажиллаж, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгчдийн эрх, ашгийг хамгаалах талаар идэвхтэй ажилладаг.
1.7. Шүүх, шүүгчийн аюулгүй байдал	Шүүхийн байр хамгаалалтад байж, шаардлагатай үед шүүгч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хангадаг, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үр дүнтэй тогтолцоо, эрх зүйн орчин, нөөц бололцоо бүрдсэн.

## 2. ШҮҮХИЙН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ

Дэд хэмжигдэхүүн	Тайлбар
2.1. Шүүгчийн сонгон шалгаруулалт	Шүүгчийн сонгон шалгаруулалт нээлттэй, ил тод явагддаг. Шүүгчийн сонгон шалгаруулах процесс, нэр дэвших явцын тухай мэдээлэл олон нийтэд нээлттэй байршдаг, шүүгч сонгон шалгаруулах бүрэн эрх бүхий байгууллагын эцсийн үнэлгээ, үнэлгээний задаргаа, тайлбар нээлттэй, ил тод байдаг.
2.2. Хууль тогтоомж	Шүүх эрх мэдлийн хүрээнд мөрдөж буй хууль тогтоомж нээлттэй, ил тод, хүн бүрт хүртээмжтэй байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд, тухайлбал, бүрэн буюу сул хараатай иргэнд зориулан сонсох, эсхүл бусад боломжит хувилбараар байршуулсан байдаг.
2.3. Шүүхийн тайлан, статистик	Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тайлан, статистик мэдээлэл нээлттэй, ил тод, ойлгомжтой, олж уншихад хялбар байдаг.
2.4. Шүүх хуралдаан	Нээлттэй шүүх хуралдаанд аливаа хүнд суртал, олон шат дамжлагаар дамжилгүй оролцох, үзэх боломжтой байдаг.
2.5. Шүүхийн шийдвэр	Төрийн болон албаны, хувь хүний нууцад хамаарах, түүнчлэн хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүхийн шийдвэрийн цахим санд оруулаагүйгээс бусад шүүхийн шийдвэр олон нийтэд нээлттэй, ил тод байдаг. Мөн шүүхийн шийдвэрийн олон нийтэд зориулсан хураангуй ойлгомжтой, хүртээмжтэй байдаг.
2.6. Хэргийн материалтай танилцах	Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч хэргийн материалтай цаг тухайд нь бүрэн, хугацаанд баригдалгүй танилцах боломжтой байдаг.
2.7. Хэрэг, нэхэмжлэлийн хуваарилалт	Шүүх дэх хэрэг, нэхэмжлэлийн хуваарилалт нээлттэй, ил тод бөгөөд энэ талаар мэдээлэл авах боломжтой байдаг.
2.8. Шүүхийн төсвийн ил тод байдал	Шүүхийн төсвийн зарцуулалтын тайлан, түүний задаргаа нээлттэй, ил тод байдаг.
2.9. Хэвлэл мэдээллийн сурвалжилга	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мөрдөн байцаалтын болон шүүхийн шатанд байгаа хэрэг, маргааныг бодитойгоор сонгож танилцуулдаг.

### 3. ШҮҮХЭД ИТГЭХ ОЛОН НИЙТИЙН ИТГЭЛ

Дэд хэмжигдэхүүн	Тайлбар
3.1. Шүүхийн тогтолцоо	Шүүгч хэрэг, маргааныг хууль дээдлэх зарчмыг баримтлан хууль ёсны, үндэслэлтэй шийдвэрлэдэг ба хэрэг, маргааныг өөрийн хүссэн шүүгчээр шийдвэрлүүлэх боломжгүй байдаг.
3.2. Шүүгчийн шударга байдал	Шүүгч хуулийг зөв тайлбарлан хэрэглэж, хэргийн оролцогчдын аль ч талд хүлээн зөвшөөрөгдөхөөр үндэслэлтэй шийдвэр гаргадаг.
3.3. Шүүгчийн зан суртахуун	Шүүгч хэргийн оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэдэг, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л шатанд оролцогчидтой зохих ёсоор, хүндэтгэлтэй харилцдаг.
3.4. Шүүгчийн мэдлэг, ур чадварын талаарх төсөөлөл	Шүүгч хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хангалттай хэмжээний онолын болон практик мэдлэг, ур чадвартай гэдэгт итгэлтэй байдаг.
3.5. Шүүхийн процессын сэтгэл ханамж	Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхийн үйлчилгээ ойлгомжтой, хүртээмжтэй, найрсаг байдаг тул шүүхийн шийдвэр хэний талд гарахаас үл хамаарч сэтгэл ханамжтай үлддэг.
3.6. Шүүхийн шийдвэрийн үндэслэл	Шүүгч шүүхийн шийдвэрээ хоёрдмол утгагүй, ойлгомжтой, үндэслэл бүхий, хэл зүй, найруулга зүйн хувьд өндөр түвшинд бичдэг.

### 4. ШҮҮХИЙН ДЭД БҮТЭЦ, НӨӨЦ

Дэд хэмжигдэхүүн	Тайлбар
4.1. Шүүгчийн сонгон шалгаруулалт	Шүүгчийг гагцхүү мэдлэг, ур чадвар, ёс зүйд нь үндэслэн өндөр босготой, шударга сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилдог.
4.2. Шүүгчийн мэдлэг, ур чадвар, дээшлүүлэх боломж	Шүүгч онолын болон практик мэдлэгээ зохих ёсоор ашигладаг, хэрэг, маргааныг хууль ёсны, үндэслэлтэй шийдвэрлэх ур чадвартай, түүнийгээ дээшлүүлэх боломжоор хангагдсан байдаг.
4.3. Шүүгчийн цалин хөлс	Шүүгчийн цалин хөлс нь үндсэн ажлаа эргэлзээгүй, бүрэн дүүрэн гүйцэтгэхэд хангалттай бөгөөд аливаа хэрэгцээнд нь хүрэлцээтэй, бусад орлогын эх үүсвэрийг ашиглах шаардлагагүй байдаг.
4.4. Шүүхийн захиргааны ажилтан	Шүүхийн захиргааны туслах ажилтнууд харилцааны болон гүйцэтгэлийн өндөр ур чадвартай бөгөөд шүүгч ажил үүргээ хэвийн явуулахад шаардлагатай хүний нөөцийн орон тоотой байдаг.
4.5. Шүүхийн барилга байгууламж	Шүүх үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулахад зориулсан барилга байгууламжтай ба шүүх хурлын танхим багтаамж сайтай, зөвлөлдөх тасалгаа, бусад шаардлагатай өрөө хүрэлцээтэй байдаг.
4.6. Шүүхийн мэдээллийн технологи	Шүүхийн үйл ажиллагаанд ашиглах мэдээллийн технологийн програм хангамж нь лицензтэй, хүчин чадал өндөртэй, аливаа халдлагаас хамгаалах чадвартай бөгөөд мэдээллийн технологийн бусад хэрэгсэл тоо хэмжээний хувьд хангалттай, хүртээмжтэй байдаг.
4.7. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо	Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийг даван туулах эрсдэлийн удирдлагын тогтолцоотой бөгөөд цаг үеийн нөхцөл байдалд хурдан дасан зохицох, үйл ажиллагаагаа уялдуулах чадавхтай.

## 5. ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ БА ХАРИУЦЛАГА

Дэд хэмжигдэхүүн	Тайлбар
5.1. Шүүгчийн ажлын гүйцэтгэл	Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л шатанд хуульд заасан хугацааг нягт баримталдаг бөгөөд хэргийн оролцогчдоос гаргасан аливаа хүсэлт, гомдлыг хугацаанд нь, зохих ёсоор шийдвэрлэдэг. Аливаа асуудлаар хүсэлт, гомдлыг хангаагүй шийдвэр гаргасан бол үндэслэлээ тодорхой дурддаг, тайлбарладаг.
5.2. Шүүгчийн хариуцлагын тогтолцоо	Шүүхийн Ёс зүйн хороо хуульд заасан чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлж, сахилгын зөрчилд холбогдсон шүүгчийн хэргийг хууль ёсны, үндэслэлтэй, хараат бусаар шийдвэрлэж чаддаг.
5.3. Шүүгчийн сахилгын зөрчлийн процесс	Шүүгчийн сахилгын зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа хуульд заасан журмын дагуу, хараат бус явагддаг, сахилгын хэрэгт холбогдох этгээдийн оролцоог хангаж чаддаг.
5.4. Сахилгын шийтгэл	Шүүхийн сахилгын хороо шүүгчид холбогдох сахилгын хэргийг хянан шийдвэрлээд үндэслэлтэй, тухайн хэрэгт тохирсон шийдвэр гаргаж чаддаг.
5.5. Шүүгчийн ёс зүй	Шүүгч шүүгчийн мэргэжлийн ёс зүйг чанд баримталж, шүүх эрх мэдэлд төдийгүй олон нийтэд үлгэр дуурайл болж чаддаг.
5.6. Шүүгчтэй холбоотой гомдлын мэдээлэл	Шүүгчийн эсрэг гаргасан гомдол, түүний төрөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээлэл нийтэд нээлттэй, ил тод байдаг.

## 6. ШҮҮХИЙН ҮР АШИГТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дэд хэмжигдэхүүн	Тайлбар
6.1. Шийдвэрлэгдээгүй хэргийн тоо	Хуанлийн жилд шийдвэрлэгдээгүй хэргийн тоо буюу хэргийн үлдэгдэл бага байдаг.
6.2. Хэрэг шийдвэрлэлтийн хувь	Хуанлийн жилд шүүх шинээр үүсгэсэн буюу хүлээн авсан хэргийг ихэнхийг нь шийдвэрлэж дуусгадаг.
6.3. Шүүгчийн ажлын ачаалал	Шүүгчийн ажлын ачаалал тэнцвэртэй бөгөөд түүний нөөц бололцоо, бодит боломжид тохирсон тоогоор хэрэг, маргаан хуваарилагддаг.
6.4. Шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал	Шүүхийн шийдвэр тогтвортой ба анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хяналтын шатны шүүхийн тогтоолоор ихэнхдээ хэвээр үлдээж шийдвэрлэдэг.
6.5. Шүүхийн үр ашгийн тухай төсөөлөл	Шүүх хуулиар олгосон эрх мэдлээ зохих ёсоор хэрэгжүүлдэг, шүүх эрх мэдлийн үйл ажиллагаа үр нөлөөтэй байдаг.
6.6. Шүүхийн захиргааны үйлчилгээ	Шүүхийн захиргааны үйлчилгээ шүүхээр үйлчлүүлж буй олон нийтэд ээлтэй, хүртээмжтэй, ойлгомжтой байдаг бөгөөд шүүхээр үйлчлүүлсэндээ сэтгэл ханамжтай үлддэг.
6.7. Шүүхийн шийдвэрийн биелэлт	Шүүхийн шийдвэрийг холбогдох этгээд сайн дураараа дагаж биелүүлдэг бөгөөд шүүхийн шийдвэрийн биелэлт өндөр байдаг.

## 2.3 ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Энэ удаагийн индексийг гаргахдаа 2021, 2023 оны индексийн нэгэн адил дараах гурван эх сурвалжаас өгөгдөл цуглуулах аргыг ашигласан.

ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ		
1	2	3
Захиргааны мэдээлэл (статистик мэдээлэл)	Олон нийтийн төсөөллийн санал асуулга (иргэд)	Мэргэжилтнүүдийн санал асуулга (шүүгч, прокурор, өмгөөлөгч, бусад хуульч)

### ОЛОН НИЙТИЙН ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА

Олон нийтээс асуулга авах ажлыг энэ чиглэлийн мэргэжлийн компани болох "Эм Эм Си Жи" ХХК 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хооронд CAWI

(интернэт/цахим хуудсанд суурилсан онлайн) болон CATI (утсаар) гэсэн аргуудыг хослуулж гүйцэтгэсэн. Судалгаанд Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн 18-аас дээш насны 2009 иргэнийг хамрууллаа.

#### Хүснэгт 4. Судалгааны түүврийн хэмжээ, бүсээр

	Ангилал	Судалгаанд оролцогчийн тоо
Бүсчлэл	Баруун бүс	256
	Хойд бүс	186
	Хангайн бүс	183
	Төвийн бүс	187
	Говийн бүс	133
	Зүүн бүс	147
	Улаанбаатар хот	917
	<b>Нийт</b>	<b>2,009</b>

Олон нийтийн асуумжид шүүгч, прокурор, өмгөөлөгч, хуульчийн ажил эрхэлж байгаа болон сүүлийн 24 сарын хугацаанд шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцсон иргэнийг хамруулаагүй, мөн түүвэрт эзлэх

хувийн тухайд шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн тоог 15 хувиас багагүй, төрийн албан хаагчдын тоог 30 хувиас ихгүй байхаар тооцсон болно. 2,009 хүнээс 15.4 хувь нь буюу 309 хүн шүүхээр үйлчлүүлж байсан иргэн байв.

## МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН СУДАЛГАА

Оюуны Инноваци ТББ 2026 оны 1, 2 дугаар сард мэргэжилтнүүд буюу шүүгч, прокурор, өмгөөлөгч, хуульчдаас асуумж авч энэхүү эх сурвалжийн өгөгдлийг бүрдүүллээ. Судалгаанд 150 шүүгч, 150 өмгөөлөгч, 50 хуульч оролцсон бол прокуроруудын хувьд асуулгад идэвхтэй оролцож 423 прокурор хамрагдсанаас мэргэжилтнүүдийн оролцооны тэнцвэртэй байдал, түүврийн төлөөлөх чадвар

зэргийг тооцож, нас, хүйсийн жинг алдагдуулахгүйгээр 423 прокурорын асуумжаас санамсаргүй түүврээр 150-ийг сонгон индекст ашигласан болно. Ийнхүү мэргэжилтнүүдийн асуулгад нийт 500 мэргэжилтэн оролцсон<sup>5</sup> нь нийт тоогоороо өмнөх индексийг гаргахад оролцсон тооноос давсан байна. Индексийн 111 шалгуур үзүүлэлтээс 55-ыг нь мэргэжилтнүүдээс авсан судалгаагаар үнэллээ.

## ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

Захиргааны өгөгдлийг 2025 онд гарсан Монгол Улсын шүүхийн тайлан, Шүүхийн сахилгын хорооны үйл ажиллагааны тайлан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас иргэн, захиргаа, эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн статистик мэдээлэл, бусад холбогдох судалгааны эх сурвалжаас Оюуны инноваци ТББ-ын судлаачид цуглуулж боловсрууллаа.

Индексийн 111 шалгуур үзүүлэлтээс 19 шалгуур үзүүлэлтийг захиргааны мэдээллээр үнэлсэн болно. Энэ удаад шүүхийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотойгоор “6.3.Шүүгчийн ажлын ачаалал” дэд дэмжигдэхүүн 3 шалгуур үзүүлэлттэй байсныг 6 болгож дэлгэрүүлснээр нийт шалгуур үзүүлэлтийн тоо 108-аас 111 болж нэмэгдсэнийг дурдах нь зүйтэй.

---

<sup>5</sup>2023 оны индексийг тооцоход 418 мэргэжилтэн оролцсон.

## 2.4 ШҮҮХИЙН ИНДЕКС ТООЦОХ АРГА ЗҮЙ

### ШҮҮХИЙН ИНДЕКС ТООЦОХ ҮНДСЭН АЛХАМ

#### 1. Өгөгдөл цуглуулах

Индекс тооцоход шаардлагатай өгөгдлийг захиргааны мэдээлэл, олон нийтийн төсөөллийн санал асуулга, мэргэжилтнүүдийн санал асуулга гэсэн гурван төрлийн эх сурвалжаар цуглуулна. Санал асуулгын асуулт бүрийн хариултыг урьдчилж тоон утгаар кодлосон байна. Бүх асуултын хариултыг бага утгаас (шүүхийн үйл ажиллагаа сул) их утга (шүүхийн үйл ажиллагаа сайн) хүртэл эрэмбэлэн нормализаци хийх шатанд бэлтгэнэ. Асуултын агуулгаас хамаарч зарим асуултын хариултыг урвуу эрэмбэлнэ.

#### 2. Өгөгдлийг цэвэрлэх, нормализаци хийх

Дутуу бөглөсөн, асуултад нэгээс илүү хариулт өгсөн, эсвэл “мэдэхгүй” гэж хариулт өгсөн асуулгыг хүчингүйд тооцон индекс боловсруулалтанд хамруулахгүй.

Өгөгдлийн санг үр ашигтайгаар зохион байгуулах, хэмжигдэхүүн хоорондын утгыг нэгдсэн байдлаар харьцуулах боломжийг бий болгох зорилгоор хариулт бүрийг 0-ээс 1 хүртэлх утгын хооронд нормализаци (min-max normalization) хийнэ. Томъёо:

$$z_i = \frac{x_i - \min(x)}{\max(x) - \min(x)}$$

$z_i$  – Нормалчилсан  $x_i$  утга

$x_i$  – Асуумжийн хариулт

$\max(x)$  –  $x$  дахь хамгийн их утга

$\min(x)$  –  $x$  дахь хамгийн бага утга

#### 3. Шалгуур үзүүлэлтийн оноо тооцох

Өгөгдлийг нормализаци хийсний дараа шалгуур үзүүлэлт бүрийн дундаж утгыг тооцно. Шалгуур үзүүлэлтийн дундаж утгыг 0-100 хүртэлх индексийн оноонд хөрвүүлнэ. Дэд хэмжигдэхүүн доторх шалгуур үзүүлэлтийн эзлэх жинг тэнцүү тооцсон.

#### 4. Дэд хэмжигдэхүүний оноо тооцох

Дэд хэмжигдэхүүний оноог тооцохдоо шалгуур үзүүлэлт бүрийн холбогдох жинг харгалзан дундаж оноог тооцно. Дэд хэмжигдэхүүний үндсэн хэмжигдэхүүн дотор эзлэх жинг тэнцүү хувиар тооцсон.

#### 5. Үндсэн хэмжигдэхүүний оноо тооцох

Үндсэн хэмжигдэхүүний оноог тооцохдоо дэд хэмжигдэхүүн бүрийн холбогдох жинг харгалзан дундаж оноог тооцсон. Үндсэн хэмжигдэхүүний индексэд эзлэх жинг тэнцүү хувиар тооцсон.

#### 6. Индексийн ерөнхий оноо тооцох

Үндсэн хэмжигдэхүүн бүрийн холбогдох жинг харгалзан дундаж оноог тооцоноор индексийн ерөнхий оноог гарган авна. Шүүхийн индекс нь 0-100 оноогоор хэмжигдэнэ. 0 оноо нь хамгийн сул утгыг, 100 оноо нь хамгийн сайн утгыг илэрхийлнэ.

## ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### 2.8. Шүүхийн төсвийн ил тод байдал

Монгол Улсын шүүхийн 2025 оны жилийн эцсийн тайланг бүрэн эхээр нь 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудаст байршуулсан<sup>6</sup> байх бөгөөд жил бүр ШЕЗ-өөс бүрэн

тайлан гаргаж, шүүхийн төсвийн зарцуулалтыг нийтэд мэдээлдэг байна. Гэсэн хэдий ч тайлан нийтлэх хугацаа тодорхойгүй, тогтмол гаргадаггүй зэргээс шалтгаалан энэ дэд хэмжигдэхүүнийг 50 хувиар үнэлэв.

**Хүснэгт 5.** “2.8.1 Шүүхийн төсвийн зарцуулалтын тайланг тогтмол гаргаж, олон нийтэд мэдээлдэг.” шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ
Тайланг тогтмол гаргаж, нийтэд мэдээлдэг /улирал бүр/	100
Тайланг гаргаж, нийтэд мэдээлдэг /жилд 2-оос доошгүй удаа/	75
<b>Тайланг заримдаа гаргаж, нийтэд мэдээлдэг /жилд 1 удаа/</b>	<b>50</b>
Тайланг гаргаж, олон нийтэд мэдээлсэн боловч бүрэн бус, эсхүл хангалттай нарийвчлан гаргаагүй	25
Тайлан гаргадаггүй эсвэл олон нийтэд мэдээлдэггүй	0

### 5.6. Шүүгчтэй холбоотой гомдлын мэдээлэл

Энэ дэд хэмжигдэхүүний хүрээнд шүүгчийн эсрэг гаргасан өргөдөл, мэдээллийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг нийтэд нээлттэй мэдээлж буй эсэхийг хянаж үзсэн. Тодруубал, шүүгчийн сахилгын зөрчлийн талаар гаргасан өргөдөл, мэдээллийн бүртгэл, хуваарилалт, Шүүхийн сахилгын хорооны

хуралдааны тов, хуралдааны тойм, Шүүхийн сахилгын хорооны шийдвэр, Шүүхийн сахилгын хорооны үйл ажиллагааны тайлан, статистик, мэдээллийг нийтэд нээлттэй мэдээлдэг эсэхийг дараах хэмжүүрээр үнэлдэг.

**Хүснэгт 6.** “5.6.1. Шүүгчийн эсрэг гаргасан гомдол, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг нийтэд бүрэн, ил тод мэдээлдэг.” шалгуур үзүүлэлтийн үнэлгээний хэмжүүр

Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ
Мэдээллийг бүрэн, ил тод тогтмол нийтэд мэдээлдэг	100
Мэдээллийг бүрэн, ил тодоор нийтэд мэдээлдэг	75
Мэдээллийг бүрэн бус байдлаар нийтэд мэдээлдэг	50
Мэдээллийг нийтэд маш ховор мэдээлсэн, эсвэл олж авахад төвөгтэй	25
Мэдээллийг нийтэд ил тод зарлаагүй	0

<sup>6</sup> [https://www.judcouncil.mn/site/news\\_full/15835](https://www.judcouncil.mn/site/news_full/15835)

2025 онд Шүүхийн сахилгын хороонд иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдээс 305 өргөдөл, 21 мэдээллийг шинээр гаргаж, өмнөх оны үлдэгдэл 17 өргөдөл, нийт 343 өргөдөл, мэдээллээс тайлант онд илтгэгч гишүүн 148 өргөдөл, мэдээлэлд сахилгын хэрэг үүсгэж, 171 өргөдөл, мэдээлэлд сахилгын хэрэг үүсгэхээс татгалзаж, үлдэгдэл өргөдөл, мэдээлэл 24 байна. ШСХ-ны цахим хуудаст 2025 онд гаргасан 326 өргөдөл, мэдээллийн бүртгэл, хуваарилалтын мэдээллийг бүрэн оруулж<sup>7</sup>, ШСХ-ны хуралдааны тов, тоймын мэдээллийг тогтмол байршуулсан.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 116.4-т “Сахилгын хорооны магадлал, хяналтын тогтоол, Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдааны тогтоолыг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 21 хоногийн дотор цахим хуудаст байршуулна” гэж заасан. ШСХ-ны хуралдаанаар илтгэгч гишүүний сахилгын зөрчлийг нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналыг ШСХ-ны 3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаанаар хэлэлцэж, сахилгын шийтгэл оногдуулах эсэхийг шийдвэрлэж, магадлал эсхүл тогтоол гаргадаг. 2025 онд ШСХ-ны хуралдаанаар сахилгын зөрчлийг нотлох 43 дүгнэлт,

сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох 140 саналыг хянан хэлэлцэж 158 магадлал гаргаснаас 152 магадлалыг нь цахим хуудастаа байршуулсан.<sup>8</sup>

